

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-21

-
- 1. “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./** 6-15
 - 2. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/** 15-18
 - 3. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал** 18-21
 - 4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/** 21-21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 19 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Ганбаатар;

Тасалсан: Т.Аубакир, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг.

Нэг. “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга Г.Эрхэмбаяр, “Дулааны цахилгаан станц-3” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, мөн компанийн Техникийн бодлогын хэлтсийн дарга Г.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн талаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Түвшин нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Н.Алтанхуяг, Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Б.Болормаа, Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга Ц.Тогосмаа, мөн газрын Олон улсын татварын хэлтсийн дарга Л.Мөнхтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Түвшин нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаандаа зөрчлөө арилгаагүй 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь заалтын дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Цолмонгийн Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 14
Бүгд: 19
26.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Г.Дамдинням нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

2.Лувсанпэрэнлэйн Батзоригийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Зандаръяагийн Баянмөнхийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 16
Бүгд: 19
15.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Жүгдэрнамжилын Эрдэмзаяаг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 14
Бүгд: 19
26.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 59 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 15 цаг 19 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Би хуралдаанд бүртгүүлсэн байгаа гишүүдээ танилцуулъя.

Далайн Батбаяр, Батмөнхийн Батцэцэг, Цэрэнпилийн Даваасүрэн, Ганзоригийн Тэмүүлэн, Баттогтохын Чойжилсүрэн, Рэнцэндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Гонгорын Дамдинням, Банзрагчийн Түвшин, Дамбын Батлут, Пүрэвжавын Ганзориг, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүд оролцож байна. Ирвэл зохих 25 гишүүнээс 13 ирсэн, ирц 52 хувьтай байгаа учраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Байнгын хорооны хуралдааны үйл ажиллагааг нээе.

Өнөөдрийн хуралдаанаар 4 асуудал байна.

1 дүгээрт “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

2 дахь асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт.

3 дахь асуудал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал байгаа.

4-д Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчдийн сонголт явуулах, сонголтын даргалагчийг томилох/ асуудал байгаа. Ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Ингээд эхнийхээ асуудалд орёе.

“Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Чойжилсүрэн сайд байна. Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Эрхэмбаяр Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга, Л.Эрхбаатар, Дулааны 3 дугаар цахилгаан станцын гүйцэтгэх захирал, Г.Амартүвшин Дулааны 3 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсийн дарга гэсэн хүмүүс оролцож байна.

Төслийн танилцуулгыг Эрчим хүчний сайд Чойжилсүрэн танилцуулна. Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 48мвт-ын хүчин чадалтай дунд даралтын хэсэг 1968-1975 онд, 100мвт-ын хүчин чадалтай өндөр даралтын хэсэг 1976-1981 онд ашиглалтад орж, 2014 онд 50мвт-ын хүчин чадалтай труба генератораар өгөгдсөнөөр суурилагдсан хүчин чадал нь 198мвт хүрсэн бөгөөд 56 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус станц нь Улаанбаатар хотын дулааны шугам, сүлжээний гидравлик горимын хувьд хамгийн оновчтой байршилд байрладаг ба Улаанбаатар хотын дулааны хангамжийн хэрэглээний 32 хувийг, төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 16 хувийг тус тус ханган ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 8-12 хувиар өсөж байгаа бөгөөд өвлийн улиралд ДЦС бол бэлтгэл тоноглолгүй ажиллаж байгаа нь насжилт өндөртэй тус станцын хувьд техникийн гэмтэл саатлаас шалтгаалан хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хязгаарлах эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд тус станцыг ойрын хугацаанд өргөтгөн, шинэчлэх шаардлагатай юм.

Улаанбаатар хотын одоогийн болон өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг найдвартай хангах зорилгоор “Дулааны гуравдугаар цахилгаан станц”-ыг 2 үе шаттай өргөтгөн, шинэчлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний үе шатад 50мвт-ын дулааны станцыг шинээр барьж, дараагийн шатад ашиглалтын хугацаа дууссан 48мвт-ын станцыг буулган суурин дээр нь 250мвт-ын ДЦС-ыг шинээр барина.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын 2021 оны хуралдааны үеэр Оросын талаас “Интер рау экспорт” компанийг Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгөн шинэчлэх төсөлд оролцохыг дахин илэрхийлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн 2021 оны 12 дугаар сард Оросын Холбооны Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Дулааны Цахилгааны станц 3” төрийн өмчит хувьцаат компани болон “Интер рау Экспорт” компани хооронд хамтран ажиллах Санамж бичгийг байгуулж, төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг эхлүүлжээ. “Интер рау Экспорт” компаниас төслийн ТЭЗҮ-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2022 оны 8 дугаар сард “ДЦС 3” ТӨХК-д хүлээлгэн өгсөн.

Төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг бодитоор тодорхойлохын тулд эхний ээлжид Эрчим хүчний яамнаас Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, Оросын талтай харилцан зөвшилцсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэлийн дагуу “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороодтой тус тус зөвшилцсөн бөгөөд Монгол Улсын Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 48 дугаар гарын үсэг зурах эрх олгох тухай захирамжаар Эрчим хүчний сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгосон.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус хэлэлцээрт 2 улсын Засгийн газрыг төлөөлөн Эрчим хүчний сайд нар 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д заасны дагуу Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрчим хүчний сайд нар хамтран баталсан бөгөөд хуулийн төсөл, түүний дагалдах тооцоо судалгааг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Улсын Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эдгээр хэлэлцээр нь Монголын талын хэлэлцээр соёрхон батлах тухай хууль батлагдсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжин, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Хуулийн төсөл танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Ганзориг гишүүн байна. Түвшин гишүүн гээд 2 гишүүнээр тасаллаа. Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Энэ олон улсын энэ хэлэлцээр өөрөө олон улсын гэрээ. Тэгээд ер нь бол Үндсэн хууль буюу ердийн хуулийн адил хүчинтэй ингээд явах ёстой. Тэгэхээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой бас нийцэж байгаа эсэх дээр тодруулах зүйл байна л даа. Тухайлбал 2022 оны сая 8 сард гэх шиг боллоо. Энэ “Интер рау экспорт” гээд компани зураг төсөл боловсруулахаар тендерийн ТЭЗҮ хийхээр шалгараад ингээд Оросын талаас явж байгаа гэж байна. Тэгэхээр энэ маань өөрөө ингээд олон улсын гэрээ хэлэлцээр маань яг энэ сонирхож батлаагүй байхад ингээд тендер нь урьдчилан зарлагдаад компани нэр

заагаад, гэрээ контракт хийгээд явах нь Монгол Улсын бас энэ хуульд нийцэж байгаа юу, үгүй юу гэдэг дээр тодруулж нэгд асуумаар байна.

2-т ер нь энэ асуудал яригдсанаас хойш нэлээн л яригдаад байгаа. Энэ өртгийн асуудал байгаад байгаа. Нийтдээ 300мвт-ын хүчин чадалтай 2 үе шаттай баригдах цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил дээр өртөг өндөр байна гээд 1мвт-ыг олон улсын жишиг дунджаар бол 1 сая орчим евро буюу нийтдээ тооцоод үзэхээр 300 орчим сая еврод багтах хэмжээний өртөгтэй гэж зарим нь яригдаад байгаа. Тэгэхээр нийт өртөг нь 1,3 тэрбум евро. Тэгээд ТЭЗҮ, зураг төслөө нэмэх юм бол үүнээс дээшээ гарна гээд байгаа юм. Тэгэхээр энэ өртөг дээр эрчим хүчний сайд маань маань яг ямархуу санал, дүгнэлттэй байгаа вэ. Яг энэ гэрээ контракт байгуулагдаад цаашаа явахаар өртөг маань бас хэд дээр очих вэ. Энэ бүтээн байгуулалтын төслийн гэдэг ийм 2 асуултыг асуумаар байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганзориг гишүүн ээ, хууль зөрчсөн асуудал байхгүй. 1 дүгээрт 2022 оны 9 дүгээр сард би сая 8 дугаар сар гээд уншчихлаа. 9 дүгээр сард ирсэн юм. ОХУ-ын Интер рау гээд компани өөрийн хөрөнгөөр урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулаад Монголын талд хүлээлгэж өгсөн. Энэ ТЭЗҮ-ийн үндэслэлээр 1 тэрбум 322 сая еврогоор энэ төслийг хэрэгжүүлбэ гэдгийг ТЭЗҮ-дээ тусгасан нөхцөл нь ийм байгаа юм. Сая таны өөрийн хэлж байгаа энэ олон улсын дундаж үнэ гэхээр Хятадын үнэ баримжаалж авч байгаа юм. 1квт нь бол дулаангүйгээр цахилгаан станцууд дээр 2 сая шахам долларын үнийн саналууд ирүүлээд байдаг. Үүнээс өндөр байгаа юм. Ийм өндөр үнээр бид нар хийлгэж чадахгүй гэдэг нөхцөлийг зөрүүлээд тавьдаг. Оросууд тэгвэл бид нар зураг төсөв гээд, одоо бол энэ чинь зөвхөн ТЭЗҮ шүү дээ. Энийгээ зургаа хийчихье. Зургаа магадалсны дараа төсөв гарна. Төсвийг дахиад магадална. Үүний дараа үнийг эргэж дахиж дахин тохирье гэдэг ийм санал тавиад байгаа юм. Бид нар бол буулга. Олон улсын дээд дундаж үнээс бол үнэтэй байна гэдэг ийм саналыг тавиад байгаа учраас урьд нь бол барилга угсралтын ажил санхүүжилтийн тухай Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг ТЭЗҮ-ийн хамт оруулчихдаг байсан бол 3 хуваагаад гэсэн үг.

Эхлээд ямар ч байсан зураг төсвөө, зургаа хийгээд төсвөө хийчихье. Үүний дараа үнээ тохирье гэдэг ийм хэлэлцээрийн үе шат явж байгаа учраас энэ дагуу оруулж ирж байгаа юм. Энэ удаа бол ямар нэгэн ийм байдлаар тендер шалгарчихсан тухай энэ Оросын компанийг шалгаруулах тухай яриа байхгүй. Оросын талтай бол нэг нөхцөл тохирч байгаа нь Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлээр санхүүжүүлбэ. Бүх улсын экспортын зээлүүд бол хүүгийн хувьд татаастай байдаг. Хугацааны хувьд урт байдаг. Гэхдээ зориулаад авч байгаа нөхцөл нь бол тухайн улсынхаа компаниудаар ерөнхий гүйцэтгэгч байна гэдэг энэ жишгийн дагуу л ОХУ талаасаа Интер Рау гэдэг компанийг шалгаруулаад манай талд санал тавиад явна.

Одоо бидний батлах эрх нь бол зөвшөөрөх эрх нь, гэрээнд гарын үсэг зурах эрх нь болбол Засгийн газар. Мэдээж Засгийн газар энэ гэрээг зурахын тулд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод урьдчилан зөвшилцөөд, түүний дараа хэлэлцээр хийгээд, буцаагаад Их Хурлаар соёрхон батлуулах ийм ажил хийнэ. Энэ бол олон ажлын дөнгөж эхэлнэ гэж ойлгож болно. Зөвхөн зураг төсөв

хоёроо хийчихье. Үүний дараа үнэ санхүүжилтийн нөхцөлүүдийг дахин ярья гэсэн ийм л ойлголт гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Тодруулъя.

П.Ганзориг: Энэ яах вэ, олон жил бас хуримтлагдаж явсан эрчим хүчний эх үүсвэр манай улсад бас тулгамдаж байгаа асуудлаа шийдэх гээд явж байгааг бол дэмжиж байгаа. Томоор нь. Гол нь энэ үнэ өртөг дээр тухайлбал энэ Интер рау гээд компанийн ТЭЗҮ-г нь бид нар авахгүй олон улсын тендер зарлаад сонгон шалгаруулаад явлаа гэж бодъё. Эсвэл Орос талаас дахиад өөр компани сонгоод тэгэхэд бид нар манай Монгол Улсын Заасгийн газар энэ өөрсдийнхөө хөрөнгөөр гаргаад хийсэн ТЭЗҮ-ийн зардал дээр санхүүгийн хариуцлага хүлээх үү. Хүлээхээр байгаа юу гэдгийг бас тодруулж асуумаар байна.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганзориг гишүүн ээ, ийм учиртай. ТЭЗҮ бол хийгдчихсэн. Манай зардал гаргахгүйгээр ОХУ-ын Интер рау гэдэг компани өөрийн санхүүжилтээр ТЭЗҮ хийгээд ирчихсэн. Одоо энэ хийсэн ТЭЗҮ-г ажлын зураг болгоё. Дараа нь ажлын зураг болоод магадалчихъя. Ажлын зургаа магадалж байна шүү дээ. Түүний дараа төсөв гарна. Түүнийг магадлаад үнэ, нөхцөл тохирч байгаа бол дараагийн барилга угсралтын ажил, санхүүжилтийн тухай хэлэлцээрүүд цаашаа үргэлжлээд явах учиртай ийм л юм. Одоо урьдчилж ирсэн үнэ хэт өндөр байгаа учраас зах зээлийн үнээс өндөр байна, буулга гэдэг шаардлагыг тавихлаар Орос талаасаа тэгвэл ТЭЗҮ-ээ боловсруулчихсан байгаа юм чинь зураг төсөв хоёроо хийгээд яг тодорхой асуудлыг ярья. Үнэтэй юм уу, үнэгүй юм уу гэдгийг дараа нь ярина гэсэн үг.

2 дугаарт дахин хэлье. Энэ юу Оросын Холбооны Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх гэж байгаа учраас Оросын Холбооны Улсын компаниудын дунд л .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Яг энэ хэлэлцээрийг манай талаас яг хэн явуулъя гээд зүтгүүлээд байгаа юм бэ. Ер нь яг ийм геополитикийн нөхцөл байдалд бид нар заавал ийм хэлэлцээр явуулах шаардлага байна уу. Одоо айлын гал голомт гэдэг шиг яг энэ цахилгаан эрчим хүчээ геополитикийн эрсдэлд оруулчихгүй байхын тулд заавал энэ хүнд хэцүү нөхцөлд байж байгаа улс орнуудтай гэрээ хэлцэл хийж байгаа юм уу.

3 дугаарт эдийн засгийн хувьд бол ингээд дараа нь үнийг нь буулгана гээд байх юм. Энэ чинь ингээд явчих юм бол одоогийнхоосоо илүү нөхцөл байдалтай гаргасан тогтоол дээрээ үнэнч байх ёстой энэ тэр гээд ингээд цаашаа улам даамжраад явчих юм биш үү. Ер нь энэ яах вэ, том төсөл ч гэдэг ч юм уу эрчим хүч гэдэг дээр дандаа гадн, дотнын зээл гээд байх юм. Энийг ер нь зогсоох боломж байгаа юу гэсэн ийм 4 асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Түвшин гишүүний асуултад хариулъя. Манайх өөрөө энэ станцыг барьчих хэмжээний санхүүжилттэй байсан бол, хуримтлалтай байсан бол заавал ийм бусдаас хараат байдлаар ийм нөхцөл байдалтай хэлэлцээр явахгүй. Бид нар төсвийн хөрөнгө оруулалтаараа станц барих эх үүсвэр байхгүй учраас тухайн үеийн Засгийн газрын нөхөд ОХУ талаасаа хандаад энд 3 дугаар цахилгаан станцын төслийг санхүүжүүлээч гэдэг ийм хүсэлт тавихаар, зөрүүлээд экспортын зээлээр санхүүжүүлж болох юм гэдэг энэ олон улсын экспортын зээл олгож байгаа Экзим банкны зээлүүдийн нөхцөлийн дагуу л энэ хэлэлцээр явж байгаа.

Хэн зүтгүүлээд байгаа юм гэдэг ийм асуулт тавьж байх шиг байна. Тухайн үед би танд хэлсэн. 2021 онд Засгийн газар хоорондын комиссын хуралдаан дээр Оросын Холбооны Улс,ы Монгол Улс Засгийн газар хоорондын комиссын хуралдааны үеэр Оросын талд Монголын талаас энийг санхүүжүүлээч гэдэг энэ саналыг тавиад, Оросын талд санхүүжиж болох юм. Энэ төслийг судалж үзэж болох юм гэдэг ийм л ойлголтын хүрээнд явж байгаа юм. Манай Эрчим хүчний яам Засгийн газрын тухай хуулиар эрчим хүчний үйлдвэрлэл бодлого, түгээлтийг Засгийн газрын тухай хуулиар Эрчим хүчний сайд хариуцдаг учраас би энэ асуудлыг хариуцаад явж байгаа гэсэн үг. Энэ Засгийн газрын үед. Цаашид ямар нэгэн даамжрах зүйл байх болов уу гэсэн ийм болгоомжлол байх шиг байна. Та шинэ гишүүн байгаа учраас бас ийм. Энэ Их Хурлын хяналтгүйгээр ийм олон улсын гэрээ байгуулагдана гэдэг зүйл байхгүй. Тийм ойлголт байдаггүй. Хуулийн дагуу заавал Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөж, гэрээ байгуулах эрхээ авчхаад, дахиад соёрхон батлахаар оруулж ирнэ. Хууль нь ийм заалттай.

Би дахин хэлье. Энэ зураг, төсөв 2-ыг нь хийгээд, олон улсын дундаж үнэтэй ойролцоо байвал энэ төслийг цаашид санхүүжүүлэх тухай, барилга угсралтын ажлыг эхлүүлэх тухай дараагийн Засгийн газар хоорондын комиссын хэлэлцээрийн төслийг оруулж ирнэ. Тэгэхгүй бол уучлаарай. Бид нар энэ Оросын Холбооны Улсаас танай энэ экспортын зээлийг авч чадашгүй нь. Ашиггүй юм байна гэдэг хариултыг өгөөд зогсоно гэсэн үг.

2 дугаарт зураг төсвийнх нь үнэ нийлээд ойролцоогоор 20 сая орчим доллароос хэтрэхгүй байна гэсэн ойлголт байгаа. Энэ зураг төсөв бол Монгол Улсын өмч болоод үлдэнэ гэсэн үг. Зурагтай болчихно гэсэн үг. Ийм л зүйл.

Ц.Даваасүрэн: Үг хэлэх гишүүн байна уу. Алтанхуяг гишүүн, Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд. Сайн байцгаана уу. Энэ Гуравдугаар цахилгаан станцын зураг төслийн асуудал зөвхөн энэ ордон дотор биш, бас сошиалаар иргэд бас нэлээн анхааралтай харж байгаа ийм халуун сэдвүүдийн 1. Тэгээд би ингэж бодож байна.

1 дүгээрт мэдээж итгэлцлийн асуудал байгаа. Би аль ээлжит бус чуулган эхэлснээс хойш хэлээд байгаа нэг зүйл.

2 дугаарт нь нөгөө мэдээлэл цогц байдлаар өгөгдөхгүй байгаатай холбоотой

3 дугаарт нь иргэд бас өмнө нь хууртагдсан асуудлууд зөндөө байдаг учраас ингээд маш сэрэмжтэй хандаад байна. Энэ тохиолдолд холбогдох ажлыг хариуцаж байгаа яам, агентлагууд мэдээллийг цогц байдлаар маш ойлгомжтойгоор өгч байх хэрэгтэй байна. Улс төрчид зөвхөн өөрсдийнхөө пи ар-д анхаарах биш, иргэдээ мэдээлжүүлж энэ бол тулгамдсан асуудал байна. Тэгэхгүй бол Чойжилсүрэн сайд бас хэлж байна. Шинэ гишүүд гээд. Бид нарт учир байгаа биш, бид нар иргэдийг төлөөлж сонгогдсон. Бид нарт эрэлт хэрэгцээ байна шүү дээ. Янз бүрээр асуулгаж байна. Янз бүрээр итгэхгүй байна бид нарт хүртэл. Тэгэхээр ийм байна. Энэ мэдээллүүдийг сонсоод байхаар ТЭЗҮ бол хийгдсэн, одоо зөвхөн зураг төслийн асуудал яригдаж байна. Энэ зөвхөн Эрчим хүчний яамны хөөцөлдөөд дагаа ажил биш буюу аль урт өмнө нь дээд түвшинд харилцан 2 улсын тохиролцоогоор явж байгаа ажил байна.

2 дугаарт Оросын Холбооны Улсын санал бол 1,3 тэрбум евро. Тэгээд Монгол талаас бол бараг 820-оод ч юм уу ийм төсөөлөлтэй тооцоололтой яваад байгаа юм байна. Тэгээд одоогоор бол энэ сайдын хэлж байгаа болон яамны холбогдох хүмүүсийн хэлж байгаагаар үнэ дээрээ тохироогүй юм байна. Ингээд юу ч гэсэн зураг төсөл хийгдэх юм байна. Тэгээд хийгдсэн хойноо харилцан зөвшилцөж чадвал тэр барилга байгуулалт нь хийгдэнэ. Үгүй бол өөр хөрөнгө оруулагч хайх юм байна. Харин гол нь санаа зовж байгаа дараагийн 1 асуудал бол ОХУ-аас өөр хөрөнгө оруулагч орж ирэх үү гэдэгт байгаа. Тэгээд энэ дээр маш сайн санаа тавьж ажиллах ёстой. Тэгээд ямар ч байсан тэгээд мэдээллийн маш сайн урсгал чухал байна. Маш хариуцлагатай ажиллах бас шаардлага байна гэдгийг сануулж хэлье гэж бодлоо. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Алтанхуяг гишүүн үг хэлье.

Н.Алтанхуяг: Чойжилсүрэн сайдад би өчигдөр бас уулзаад хэлсэн л дээ. 1 дүгээрт байна шүү дээ. Даваасүрэн дарга ч мэдэж байгаа. Бид нар Их Хурал дээр ийм асуудал ярьдаггүй шүү дээ. Тэрбум 300 сая евро ч юм уу, үүгээр юм хийх гэж байна гэвэл хэлэлцээрийг батлах тухай эсэх асуудлаар Их Хурал ярьдаг. Зураг станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах гэдэг ийм асуудал ерөөсөө Их Хурал дээр яригддаггүй. Энд бол Засгийн хэмжээний мөнгөний асуудал. Тэгээд тэр зураг төслөө гаргахаа бол засаг шийдээд явдаг л даа. Би энэ удаа ингэж орж ирэхээр нь жаахан гайхаад, өчигдөр уг нь би санаа хэлсэн юм. 1 дүгээр асуудал. Тэгэхээр энийгээ буцааж аваад, тэгээд юмаа хийгээд явж болохгүй юм уу. Одоо ингээд энэ улсын хэмжээгээр улс орон даяараа ингээд 2 улсын харилцааны асуудлыг энэ нэг станцаас болоод ингэж янз бүрээр ярилцах хэрэг байна уу. Одоо нэг талаасаа Орос шахаад ч байгаа юм шиг, 1 талаасаа манайх авах гээд ч байгаа юм шиг ийм ойлгомжгүй байдал үүсгээд. Ер нь ийм юм. 4 дүгээр цахилгаан станцын чадлыг манай Засгийн газар буюу тэр 123мвт-аар нэмэгдүүлсэн юм. Тэрнийг Орос, Монгол хамтраад хийсэн. Хэдээр хийсэн юм. 80 сая доллар хүрээгүй. 123-ыг 80 сая доллар хүрэхгүйгээр хийсэн. Тэгэхдээ тэр бол шинээр босгож байгаа юм биш шүү дээ. Байгаа юм дээр хийж байгаа.

2 дахь нь бол 3 дугаар цахилгаан станцыг 50мвт-аар өргөтгөсөн. Тэрнийг 35 сая ам.доллараар хийсэн. 1мвт нь 1 сая доллар хүрэхгүй. Өнөөдөр дэлхий дээр 1мвт нь бүр үсрээд үсрээд 2 сая доллар л хүрэх болов уу. Тэгэхээр бид нарын ийм асуудал Засгийн газар ингэж оруулж ирж, бид нарын ярих ёсгүй асуудлыг ярьж, улс орон даяараа нэг станцын өргөтгөлийн зургийн тухай асуудал.

Иргэд бол зураг гэж ойлгохгүй байгаа юм байна лээ шүү дээ. Энэ зээлийг авах гэж байна гэж ойлгож, ингэж үзээд байгаа юм байна лээ. Тэгэхээр энийгээ ер нь засаг дээр яриад, та нар маань Их Хурал дээр ярихгүйгээр шийдчихэж болохгүй юм уу. Манайх 123мвт-ын өргөтгөлийг хийнэ гэж лав л Их Хурал дээр ийм юм яриагүй. Тэр дотроо бүр зураг төсөл боловсруулна гэж бүр яриагүй. Иймэрхүү байдалтайгаар Чойжоо би өөрт чинь өчигдөр бас нөхөрсөг зөвлөгөө өгсөн шүү дээ. Ер нь энэ Монгол Улсын Засгийн газар жаахан юмаа боловсруулаад аятайхан ороод ирж болохгүй юм уу. Нэг түүхийн юм оруулж ирээд л ингээд л гишүүд ярилцаад л, тэгээд улс орон даяараа ярилцаад л, тэгээд тэрнийгээ буцааж татаад л энэ жаахан буруу юм биш үү гэдэг ийм юм би хэлсэн шүү дээ. Үгүй ээ, чи надад тайлбар өгөөд яах вэ дээ. Энэ Монголын түүхэнд ийм зураг төсөл оруулна 20 сая доллар гээд ордоггүй юм л даа. Та нар өөрөө 1 тэрбум 300 сая еврогийн тухай ярьж байна шүү дээ. Тэгэхээр ийм юм ингэж хийхгүй. Этикгүй, ёс зүйгүй л байна гэж би хэлээд байна. Их Хурлын гишүүдийг ч гэсэн эвгүй байдал руу түлхээд л, тэгээд бид нар ийм мэдээлэл дутуу.

Одоо тэгээд яах юм. Үүгээр 20 сая доллароор хийлгэчхээд, дараа нь үнэ дээрээ тохирсонгүй гээд болих юм уу. Тэр өмнөх Ерөнхий сайд Хүрэлсүхийн үед тохирчихсон юм гэж. Үгүй ээ, энэ өмнөх засгууд чинь юм тохирохгүй байна шүү дээ. Санаа бол яригдаж л байсан байх. Одоо яг детальчлаад юм хумаа яриад л бодитойгоороо хийгээд явбал. Дахиад Чойжоо одоо Багануур дээрээ тэр станцаа босгочихвол уг нь 300мвт-ыг үйлдвэрлэх гэж өчнөөн сая тонн нүүрс Улаанбаатар луу бас тээвэрлэхгүй болох байхгүй юу. Тэгэхээр яг 3-ын тэр байр суурь дээр босгоно гэдэг юмыг яг хэн шийдчихсэн юм. 300-гаар өргөтгөнө гээд бас хэн шийдчихээд байгаа юм. Ингээд энэ танай салбарын хувьд шийдэх ёстой асуудал байгаа.

Эгийн голын УЦС 310мвт-аар шинэ ТЭЗҮ хийгдсэн юм. Тэр өөрөө нэг миллиард 1 тэрбум.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Энд чинь хариулт байхгүй. Нөгөө үг хэлж байгаа учраас. Үгүй ээ, үгүй. Хариулт дуусчихсан. Нөгөө асуулт хариулт чинь явчихсан. Одоо зөвхөн үг байгаа байхгүй юу. Тэгэхээр дэг зөрчигдөх гээд байна. Тэгэхээр энэ дээр нэг ийм асуудлууд байгаад байгаа юм. Тэгвэл чи үг хэлэхэд нэрээ өгөх байсан байхгүй юу. Энэ чинь болохоор Засгийн газар хоорондын хэлэлцээр байгаад байгаа юм. Зээлийн хэлэлцээр биш байгаа юм. Тэгэхээр манай Байнгын хороогоор орох ямар ч шаардлагагүй байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр ямар нэг одоо зээлийн дүн байхгүй. Тийм учраас манай Байнгын хороо бол буцаасан нь дээр байх. Яагаад гэвэл энэ дээр одоо тэдэн сая доллар авна гэсэн юм ерөөсөө юу ч байхгүй. Зүгээр л зураг төсөв хийнэ гэж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт гишүүдийн хэлээд байгаа үнэн. Ер нь бол дэлхийн зах зээл дээр би зүгээр Европт байдаг зах зээлийн үнэ хэлж байгаа юм шүү. Хамгийн орчин үеийн автоматжсан ийм өндөр технологитой станц 1 сая евро л байхгүй юу 1мвт нь. Намайг сайдаар ажиллаж байхад эднийх ямар санал ирүүлсэн юм гэхээр 600 гаруй сая еврогийн санал ирүүлсэн байхгүй юу. Би тэр үед 2 дахин үнэтэй байна гээд аваагүй юм. 2 дахин үнэтэй байна гээд аваагүй юм. Одоо энэ маань 4 дахин үнэтэй болчихсон явж байгаа байхгүй юу. Байж болохгүй байна. Тэгэхдээ өнөөдөр бидний ярьж байгаа юм нөгөө зээлийн хэлэлцээр биш. Зөвхөн зураг төсвийн юм ярьж байгаа учраас би зүгээр протоколд үлдээх агуулгаар хэлж байгаа шүү. Энэ хэзээ ч байж болохгүй зүйл. Би 2 дахин байхад нь аваагүй юм шүү дээ. Тийм

учраас 4 дахин байхад нь бол бүр авч болохгүй зүйл. Нэг ийм зүйл байгаа юм. Тэгээд Алтанхуяг гишүүний хэлээд байгаа үнэн. Энэ чинь зүгээр нэг зураг төсөв хийх Засгийн газар хоорондын хэлэлцээр энэ манайхаар орох ямар ч шаардлагагүй байгаа байхгүй юу Төсвийн байнгын хороогоор.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн гишүүн үг хэлье.

Б.Чойжилсүрэн: Алтанхуяг гишүүн санал хэлж байна. Даваасүрэн гишүүн санал хэлж байна. Яагаад Засгийн газар хоорондын хэлэлцээр болгож оруулж ирсэн гэдгээ хэлье. Манай тендерийн хуулиар хэрвээ бид нар ТЭЦ-3 нээлттэй тендер зарлах юм бол ОХУ-ын компани шалгарахгүй байх магадлалтай. Тийм учраас Оросын Холбооны Улсын компанийг шалгаруулахын тулд энэ Засгийн газрын хэлэлцээрийг урьд нь байгаагүй кэйс гэсэн үг. Таны шүүмжилж байгаа үнэн. Энэ Оросын Холбооны Улсын экспортын зээлээр хэрэгжүүлэхэд ТЭЗҮ-г нь Оросын Холбооны Улсын тоног төхөөрөмжид зориулж, зураг төсөв хийхээс өөр аргагүй болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас энэ Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж байж Тендерийн хуулийн дагуу биш энэ зураг төсвийг нь хийгээд үзье гэж байгаа юм. Зураг төсөв хийгээд үнэ нь таалагдахгүй байгаа, саяын хэлээд байгаа Даваасүрэн даргын хэлээд байгаа, Алтанхуяг гишүүн таны хэлээд байгаа иймэрхүү өндөр үнэтэй зах зээлийн бус үнэ ирчхээд байгаа учраас бид нар энийг чинь 2 жил гацаагаад, гэрээг байгуулж чадахгүй байгаа юм. Буулга, зах зээлийн үнэтэй хийе гэхээр зураг төсвөө хийгээд, тодорхой болгосны дараа та нартай үнээ тохироод үзье гэдэг эцсийн зорилго явж байгаа ийм л асуудал. Тэгэхээр бид нар бол зураг төсөв бол Монголын талаасаа санхүүжилтийг ТЭЦ 3 өөрөө гаргана. Зураг, төсөв 2 маань Монголын өмч болоод үлдэх юм. Ийм л сэдэв байгаа. Энэ асуудлыг 1 талд нь гаргаад, Оросууддаа тохирохгүй бол дараагийн хөрөнгө оруулагч нарт санал гаргах хэрэгтэй.

2 дугаарт та яриад байна. ТЭЦ-3-ыг яагаад Багануур дээр барьчихгүй ТЭЦ 3 дээр бариад байгаа юм бэ. Хот руу нүүрс зөөгөөд байна гээд. Энэ Улаанбаатар хот маань өөрөө дулааны өндөр дутагдалтай болчихоод байгаа учраас дулаан цахилгаан 2-ыг ТЭЦ-3 дээр барихаас өөр аргагүй болчихоод байгаа. Хамгийн хотын төвд, хамгийн дулааны дутагдалтай байгаа хэсэг дээр байрлаж байгаа байрлал учраас 360 мвт-ын дулаан бас байгаа. 300мвт-ын цахилгааны эх үүсвэрээс гадна. Тийм учраас дулааны асуудлаа ч шийдье. Цахилгааны асуудлаа шийдье гээд энэ ТЭЗҮ-г нь оновчлолыг намайг сайд болохоос өмнө 2 талаасаа тохирчихсон юм байна лээ. 2022 оны 9 дүгээр сард энэ ТЭЗҮ-г Интер рау компани хүлээлгэж өгсөн. Би 8 сарын 30-ны өдөр Эрчим хүчний сайдаар томилогдож очсоны дараа 10 гаруй хоногийн дараа ийм асуудал болсон юм.

Тэгэхдээ би урд талын сайд нарын хувьд би сайд болж очоод оновчлолын хувьд Эрчим хүчний яамны хувьд бол дулаан, цахилгаан 2-ыг энэ ТЭЦ-3-ын байгаа энэ дэд бүтцийг ашиглаад барих ганц боломжтой нь энэ юм байна лээ. Үүнээс өөр ийм усны асуудал шийдэгдсэн, төмөр замын асуудал шийдэгдсэн ийм дэд бүтэцтэй газар байрлал Улаанбаатар хотод харамсалтай нь байхгүй байгаа учраас энийг бол би сайдын хувьд дэмжээд явж байгаа. Ийм л юм.

Ц.Даваасүрэн: Тэгэхдээ энэ чинь зээлийн гэрээ биш юм байна лээ шүү дээ. Яах вэ, нөгөө олон улсын гэрээ бусад Байнгын хороогоор орно гэдгээр л оруулсан юм шиг байна л даа. Биш ээ, энэ чинь олон улсын гэрээ юм байна лээ. Засгийн газар батлах.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо “Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 19 гишүүн оролцсноос 8 гишүүн дэмжиж, 42,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Батцэцэг гишүүн дэмжсэн юм байна. Батцэцэг гишүүнийг протоколд дэмжсэнээр авъя. Ингээд соёрхон батлуулах асуудал дэмжигдсэнгүй.

“Монгол Улсын Улаанбаатар хотын гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

“Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

15.49 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Би товчхон та бүгдэд бас энэ 04 дүгээр дүгнэлтийг танилцуулчихъя.

Татварын ерөнхий хуулийн Үндсэн хуулийн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн шүү дээ. Энэ Үндсэн хуулийн биш.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүүл шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн байна.

Тэгээд хэлэлцээд дараах дүгнэлтийг гаргасан байна.

1 дүгээрт Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, татвар төлөгчийн талаар Татварын алба, татвар төлөгчийн

зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална л гэсэн заасныг зөрчсөн байна гэж үзсэн байна.

2-т Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад Татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчдийн талаарх мэдээллийг Татварын албаны шаардлагаар тухай бүр, 34.4.3 дахь заалтад татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг Татварын албанаас бичгээр эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэсэн гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчөөгүй байна гэж үзсэн.

3 дахь нь Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 11дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй гэж ингэж үзсэн байна.

4-д энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг 15 хоногийн дотор хэлэлцэн ирүүлэхийг Улсын Их Хуралд даалгасан юм байна.

Ингээд тэр даалгасны дагуу бид нар өнөөдөр Байнгын хороогоороо ингээд хэлэлцээд явж байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс итгэмжлэгдсэн төлөөлөгч ямар хүн байна. Жавхлан сайд. Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимэдсүрэн, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Б.Болормаа Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга, Ц.Тогосмаа Татварын Ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийн газрын дарга, Л.Мөнхтуул Татварын ерөнхий газрын Олон улсын татварын хэлтсийн дарга гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Итгэмжилсэн төлөөлөгч болон ажлын хэсгээс асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асууж, хариулт авч дууслаа.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Ганзориг гишүүнээр тасаллаа. Ганзориг гишүүн үг хэлье.

П.Ганзориг: Энэ Үндсэн хуулийн цэцээс гарсан дүгнэлтийг бас уншиж танилцсан. Бас нэлээн дэлгэрэнгүй, тодорхой үндэслэлтэй ийм зүйлүүд заагдсан байна лээ. Тэгээд Их Хурлаар хэлэлцээд, Их Хурал хүлээж авсан тохиолдолд цаашаа бас дүгнэлтийг хүлээж авсны дараа зохицуулалтуудаа тодорхой болгоод явах байх гэж бодож байна. Ер нь яах вэ, энэ татварын асуудал бас орж ирж байгаа дээр өнөөдөр манай Монгол Улсын бас төсвийг бүрдүүлж байгаа хувийн хэвшил, ер нь улс орны хөгжлийг бол хувийн хэвшил бий болгодог. Аль ч улсад ажлын байр, татварын орлого, тухайн салбарын хөгжил гээд ингээд салшгүй холбоотой. Тэгээд энэ татварынхаа бодлого дээр бид нар бас хууль, эрх зүйн

орчныг бүр цогцоор нь зохицуулалтууд дээр бас харж, энэ татварын дарамт, процессын хүндрэл асуудлуудыг бас цэгцлэхгүй бол болохгүй байгаа зүйл бол нэлээн олон бас тооцоо, судалгаа, дүгнэлтээр бол харагдаад байгаа.

Би өмнө нь бас хэд хэдэн чуулган дээр асуудал хөндөж байсан юм. Энэ данс хаадаг. Одоо яг энэ жилийн эцэс болчихсон. Нөгөө төсвийн орлогоо бүрдүүлэхийн тулд дансаа хаагаад эхэлчихсэн байна лээ. Хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн группүүд байдаг. Тэр дээр төсвийн орлого бүрдүүлэхийн тулд дандаа захиргааны арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Тэгээд энэ зохицуулалтууд нь ихэнхдээ л хааж боож байгаад, орлогоо бүрдүүлэх, хувийн хэвшлийг дарамталдаг. Тэгээд данс хааснаас болоод 1 татварын дүүргийн дарга, хэлтсийн дарга данс хааснаас болж тухайн байгууллага хувь заяаг шийддэг. Дампуурах уу, үгүй юү гэдгийг. Хэзээ нээхийг бас шийддэг. Энийгээ дагаад авлига цэцэглэдэг. Данс хааж, нээж тоглодог ийм байдал бол их байгаа. Тэгэхээр цаашдаа бол энэ татварын асуудлуудыг бол бид нар бас Их Хурал дээр нэлээн ярих зайлшгүй шаардлагатай байгаа.

Нөгөө талдаа Их Хурлын гишүүд бас энэ татварын асуудлуудыг хөндөх эрхийг нь хязгаарлалчихсан байгаад байгаа. Тэгээд Засгийн газраас энэ татварын асуудалтай холбоотой хувь хэмжээ тогтоох тухай асуудлуудыг бол бас Засгийн газраас л өргөн барих боломжтой байгаад байгаа. Энэ дээр бас цаашдаа Төсвийн байнгын хороо болон бусад гишүүддээ санаачилга гаргаж, хамтарч ажиллахыг бас хүсье хүсье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ингээд Түвшин гишүүн ороогүй байгаад байгаа юм уу. Орохгүй байгаад байгаа юм уу.

Б.Түвшин: Тэгэхээр энэ цэцийн дүгнэлтийг ер нь хүлээж авах нь зүйтэй. Татварын харилцаа өөрөө иргэний хоорондын бизнесийн харилцаа. Тэгээд сүүлийн үед энийг захиргааны болон бараг эрүүгийн хариуцлага шиг болгоод явчихдаг. Бизнес эрхлэгчдийн хувьд аккруэл сууриар тооцоод орлогоо өөр байдлаар тооцоод явчихдаг. Нөгөө талд нь бол татварыг шууд мөнгөн сууриар тухайн сард нь хурааж авах Ийм захиргааны арга хэрэгслүүдийг хэрэглээд явчихдаг. Энэ асуудлыг бас бид нар зөвхөн энэ цэцийн дүгнэлт гэлтгүй цааш цаашдаа бас иргэний харилцаа руу шилжүүлмээр байгаад байгаа юм. Хэдийгээр бид нар нэг талдаа төр засгийг төлөөлж явж байгаа боловч тэр бизнес эрхлэгчдийн мөнгөн уялдаа, бизнесийн онцлог, тэгээд ялангуяа дэлхий нийт олон улсад хэрэглэгддэг тэр татвар төлөх боломжууд аккруэл суурийг цаашдаа бид нар ч гэсэн эндээ хэрэглэж, тэрэндээ таарсан арга хэмжээнүүдийг авахгүй бол Засгийн газрын хэрэгжүүлж явуулж байгаа төсөв хөтөлбөрүүдийг цуглуулах ажлын аппарат болж болохгүй болчихож байгаа юм.

Тийм учраас бизнес эрхлэгчдийн харж байгаа татварын бодлого төрөөс явуулж байгаа татвар хураах, тодорхойлох энэ бодлогыг олон улсад байж байгаа арга зам руу нь шилжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Цэцийн дүгнэлт бол ер нь бол яг бизнес эрхлэгчдийг хамгаалсан тал руугаа гарсан байгаад бол их таатай байна. Энийг цаашдын олон хууль, ер нь олон олон татвар хураах процессууд дээр олон улсад хэрэглэдэг аргуудыг хийхгүй бол өнөөдөр манайд явж байгаа захиргааны болон эрүүгийн аргууд нь бол бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг явуулахад саад болж байна. Тэгэхээр цаашдаа

үүгээр тогтохгүй олон олон асуудлуудыг шийдэх хэрэгтэй байн гэдэг ийм саналыг хэлье.

Ц.Даваасүрэн: Мөнхсоёл гишүүн алга байна. Ингээд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаандаа зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 42,1 хувиар дэмжигдээгүй байна.

Гэхдээ хэн гишүүн Түвшин гишүүн бол протоколд дэмжигдсэнээр авъя. Тэглээ ч гэсэн хүрэхгүй байна. Ингээд уг санал дэмжигдсэнгүй. Санал хураалтын дүнг танилцууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Батлут гишүүн танилцуулчих уу. Батлут гишүүн танилцуулчихъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

16.00 цаг.

3 дахь асуудал.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнийг Төсвийн байнгын хороо нэр дэвшүүлэхээр заасны дагуу Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг бид нар баталж, сонгон шалгаруулалтын зарыг нийтэд хүргүүлсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс 18-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл Төсвийн байнгын хорооны 213 тоот өрөө болон Төрийн ордны шуудангаар бичгээр, цахимаар материалыг хүлээж авлаа.

Энэ хугацаанд нэр дэвшихээр хүсэлт ирүүлсэн 4 хүний материалыг та бүхэнд цахимаар хүргүүлсэн байгаа. Нэр дэвшихээр хүсэлт ирүүлсэн 4 материалын талаар товч танилцуулга хийгээд, цагаан толгойн үсгийн дарааллын дагуу санал хураалт явуулах ёстой юм байна.

Нэр дэвшигчийг дэмжсэн тохиолдолд дараагийн хүний санал хураалгахгүй гэсэн ийм дүрэмтэй юм байна. Тэгэхээр одоо би та бүхэнд нэр дэвших хүсэлт ирүүлсэн материалын талаар хүн бүр дээр товчхон танилцуулчихъя.

Эхний хүн Ц.Бархас 1989 онд төрсөн. 35 настай. СЭЗИС-ийн Эдийн засгийн бакалавр, Виржиниагийн Олон улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, эдийн засагч мэргэжилтэй. 2015-2016 онд Голомт банканд менежер, нарийн бичгийн дарга, 2016-2020 онд “Таван богд” ХХК-д ахлах менежер, албаны дарга, ерөнхий менежер, 2021 онд “Ард санхүүгийн нэгдэл” ХК-д Маркетинг хариуцсан захирал, 2022-2024 онд “Ард секьюритс” Үнэт цаасны компанид гүйцэтгэх захирал, 2024 оноос “Сентрал Коммерс” ХХК-д захирлаар ажилласан байна.

2 дахь хүн Л.Батзориг. 1988 онд төрсөн 36 настай. СЭЗИС-ийн Эдийн засгийн бакалавр, Шихихутаг их сургуулийн эрх зүйн бакалавр, Санхүүгийн менежментийн эрх зүйч мэргэжилтэй юм байна. 2009-2019 онд Худалдаа хөгжлийн банкны эдийн засагч, салбарын захирлын үүрэг гүйцэтгэгч, 2022 онд “Мод хөтөлбөр” ХХК-д гүйцэтгэх захирал, 2011 онд “Ар анд түнш” ХХК-д одоо захирлаар ажиллаж байгаа юм байна.

3 дахь хүн З.Батмөнх. 1982 онд төрсөн хүн байна. ШУТИС-ийн Компьютер технологийн мэдээллийн сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Япон улсын Сайтамагийн их сургуулийн Эдийн засгийн магистр, үйлдвэрлэлийн удирдлагын мэргэжилтэй. 2005 оноос Сангийн яаманд ажиллаж байгаа. Одоо ахлах мэргэжилтэн хүн байна.

4 дэх хүн бол Ж.Эрдэмзаяа 1984 онд төрсөн. СЭЗДС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн эдийн засгийн магистр, санхүүгийн менежмент мэргэжилтэй. 2006-2011 он, 2020 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуульд багш, 2013-2014 онд Хөрөнгийн зах зээлийн судалгааны төвд гүйцэтгэх захирал, 2014-2015 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд статистик судлаач, 2016-2020 онд Сахүүгийн зохицуулах хороонд мэргэжилтэн, ахлах референт, 2024 оноос “Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” дотоод зөвлөх буюу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн Санхүүгийн эрсдэлийн мэргэжилтнээр хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа ийм хүмүүс байна.

Ингээд санал хураалт явуулж эхлэх үү. 1 1-ээр нь юм байна. Үгүй ээ, энэ чинь тэгээд эхний хүн дэмжигдчихвэл дараагийнх нь хураахгүй юм байна шүү дээ. 4 хүнийг. Тэгээд эхний хүн нь энэ санал хураалт явуулах юм байна.

Одоо ингээд эхний хүн цагаан толгойн үсгийн дарааллаар Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналыг манайх 1 л хүнийг явуулах байхгүй юу. Манайх 1 л хүн. Манай байнгын хороо 1 л хүн явуулна шүү. Тэгээд эд нараас хамгийн олонхын санал авсан хүн л явах юм байна. Одоо жишээлбэл Бархасыг хураагаад Бархас олонхын санал авчих юм бол Бархас нь шууд болох нь байна. Хэрвээ Бархас ингээд олонхын санал авч чадахгүй бол би дараагийн хүнийг хураалгаад явах нь байна шүү. Үгүй ээ, тэгэхгүй болохоор чинь тэгээд юу болчихно шүү дээ. Үгүй ээ үгүй цагаан толгойн үсгийн дарааллаар нь явахгүй бол тэгээд дараа нь тэрийг орууллаа, энийг урд нь орууллаа гээд унах байлгүй. Үгүй ээ үгүй. Та нар ингэж болно шүү дээ. Та нар тэгэхээр дэмжиж байгаа, дэмжихгүйгээ илэрхийлэхээр

явчихна шүү дээ. Эхний хүнийг дэмжихгүй байгаа бол дэмжихгүй, дэмжиж байгаа бол дэмжиж байгаагаар л явна гэсэн үг. Тэгвэл би дараагийн хүнийг нь хураалгаад явах юм байна. Тийм 1-ийг нь энэ 4-өөс сонгоно. Ингээд хамгийн өндөр санал авсан хүн л гарах нь. Үгүй ээ, бид нар бүгдээрээ өгч чадвал болно. Чадахгүй бол болохгүй гэсэн үг байхгүй юу. Санал хураалт явлаа шүү. Одоо хэдэн гишүүн байна. 10 байгаа юм байна шүү дээ. 11. ганц 2 гишүүн оруулах уу. Арай бас жоохон эрсдэлтэй байна уу.

Гишүүд ээ, цагаан толгойн үсгийн дарааллаар Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Заяабал гишүүн горимын санал гаргая. Тэгээд тэр хооронд ирцээ бүрдүүлэхгүй бол болохгүй юм байна. Тэгээд л өөрсдөө шийд гэж байна шүү дээ.

Б.Заяабал: Байнгын хорооны дарга сая санал хураалтад би хуруугаа уншуулаад авсан мөртөө яг зөвшөөрсөн дээр дарсан чинь идэвхгүй байгаад байх юм. Ингээд саарал өнгөтэй. Татгалзсан ч үгүй ээ, хугацаа хоцроогүй, тийм учраас дахиж санал хураалгаж өгнө үү гэсэн ийм горимын санал гаргая.

Ц.Даваасүрэн: Хүчингүй болгоод уу. Юу ч гэсэн мань хүний саналаар санал хураалт явах уу. Түр дараагийн асуудал руу орж байя тэгэх үү. Түр дараагийн асуудал руу. Үгүй ээ энэ чинь хөөш ерөөсөө маш амархан шууд хараач дараагийн асуудал.

Ингэе гишүүд ээ, одоо ингэе. Эхнээсээ явъя. Тэгэхээр одоо байна шүү дээ. Заяабал гишүүний гаргасан горимын саналаар эхний саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна шүү. Заяабал гишүүн ээ, Батцэцэг гишүүн ээ анхаараарай. Эхний саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Ирц ч хүрээд байна л даа. Ирц хүрээд байгаа юм. Үгүй ээ, тэгэхээр бүгдээрээ өгч байж дэмжигдэх болчихоод байна шүү дээ. Тэгэхээр чинь харин бүгдээрээ өгч байж дахин санал хураагаад явах болчихоод байгаа байхгүй юу. Бүгдээрээ өгчхөөд хэдүүлээ яачихъя л даа.

Заяабал гишүүний гаргасан горимын саналаар эхний санал хураалтыг техникийн асуудалтай байсан учраас хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Тэгвэл протоколд Заяабалыг дэмжсэнээр 6 гэж авлаа шүү. Бархасыг 6, Дамдинням гишүүн 7. Ингээд 7 хүн Бархасыг дэмжсэн байна шүү 7.

Дараагийн Лувсанпэрэнлэйн Батзоригийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний нэр дэвшихийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 4 хүний санал авсан байна.

Дараагийн хүн Зандаръяагийн Батмөнхийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшихийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 19-3 хүн дэмжиж, энэ хүн дэмжигдсэнгүй.

4 дэх хүн Жүгдэрнамжилын Эрдэмзаяаг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшихийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 19-5. Ингээд хамгийн олон хүний санал авсан нь Бархас боллоо.

Ингээд нэр дэвшигчдийг Төсвийн байнгын хорооноос нэр дэвшүүлэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.6-д заасны дагуу хэлэлцэж дууслаа. Тэгээд дү дүн нь юу байх юм. Байж байгаарай 4 дэх асуудал байгаа.

Ингээд хамгийн олонхын саналыг Цолмонгийн Бархас 7 хүний саналаар авсан тул нэр дэвшүүлэхээр дэмжлээ.

16.17 цаг.

4 дэх асуудал.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, Сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх, асуулт асуух гишүүн байна уу. Үг хэлж, асуулт асуух гишүүн алга байна.

Нэр дэвшигчийн сонсгол даргалах нь манай Дамдинням гишүүн байгаа. Ингээд “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, Сонсгол даргалагчийн сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 19 гишүүн санал хураалтад орсноос 10 гишүүн дэмжиж, уг тогтоол дэмжигдлээ.

Батжаргал гишүүн дэмжсэн юм байна. Протоколд авъя. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн асуудал хэлэлцэж дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

Гишүүд ээ, энэ 3 дахь асуудал дээр дахин асуудлыг авч үзэхгүй бол болохгүй болчихлоо. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудал дээр тухайн хүн Дэгийн тухай хуулийн 111.6-аар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэн байх ёстой юм байна. Хамгийн олон санал авснаар биш сая бол 19-7 хүн гээд хамгийн олон санал авсан Бархас гэж үзсэн чинь үгүй юм байна. Яагаад гэвэл 19-10-аас дээш гишүүний санал авч байж энэ хүн дэмжигдсэнд тооцох юм байна. Тэгэхээр саяын санал хураалтад оролцсон 4 хүн дөрвүүлээ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал аваагүй байна. Тэгээд энэ асуудлыг дахиж авч үзэхээс өөр аргагүй болчихлоо.

16.18 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ